



БАЯНЧАНДМАНЬ СУМЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2013 оны Санхүүгийн Тайлан

ҮАГ-ын Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйл байвал 70272248
дугаарын утаснаас лавлана уу?
Л.Жаргалсайхан
Аймгийн Тэргүүлэх аудитор
өрөөний утас 70272582

Ц.Саранчимэг - Аудитор
өрөөний утас 70273465

Аймгийн Аудитын газар
Төрийн байгууллагын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

• Аудит хийж дууссан тухай мэдэгдэл	2-3
• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4-8
• Гол шийдлүүд	9
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	9
• Аудитын санал дүгнэлт	9

**Төв аймгийн Баянчандмань сумын төсвийн байгууллагууд,
тусгай сангууд 2013 оны Санхүүгийн Тайлан
аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Баянчандмань сумын төсөвт байгууллагууд болон тусгай сангуудын 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба Сумын Засаг дарга болон төсвийн шууд захирагч болон Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Баянчандмань сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг тодруулбал:

- Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

- ✓ Сумын Орон нутгийн төсвийн татварын орлогыг тодотгож 52166,2 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 60169,7 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөг 8003,5 мянган төгрөгөөр буюу 115,3 хувиар давуулан биелүүлсэн байна.
- ✓ ХХМБаг ажиллаж 15012,4 мянган төгрөгийн зардал гаргасан байхад орон нутгийн орлогод хог хаягдлын хураамжаар 2400,0 мянган төгрөг орсон байна.

*ЕМ, Санхүүгийн албанаас
ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын
Газар тайлбар мэдүүлэг хүлээж байгаа
илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар
тайлбар ирүүлнэ үү*

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн, дээрх зөрчлүүд материаллагын урьдчилан

тогтоосон түвшингээс бага тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Ерөнхий аудитор т санал оруулсан байгаа

- ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын Газрын дарга, Тэргүүлэх Аудитор 2014.03.25-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч, нярав болон бусад албан тушаалтан бидэнтэй хамтран ажиллаж бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

**ҮАГ-ЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

Танилцуулга

Баянчандмань сумын 2013 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба сумын Засаг даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх;

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

Аймгийн Аудитын газар санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Баянчандмань сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын хяналтыг аймгийн Аудитын газрын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Бид Баянчандмань сумын Засаг дарга тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Баянчандмань сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

Орлого санхүүжилтийн талаар:

Баянчандмань сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2012 оны 12-р сарын 19-ний өдрийн 01-р хуралдааны 04-р тогтоолоор сумын Орон нутгийн төсвийн татварын орлогыг 32188,4 мянган төгрөгөөр баталсан ба тайлант онд орлогыг тодотгож 52166,2 мянган төгрөг ба гүйцэтгэлээр 60169,7 мянган төгрөг төвлөрч батлагдсан 8003,5 мянган төгрөгөөр буюу 115,3 хувиар давуулан биелүүлсэн байна. Энэ нь хүү торгуулийн орлого 13077,0 мянган төгрөг гүйцэтгэлээр 22683,5 мянган төгрөг орж 9606,5 мянган төгрөгөөр буюу 173,5 хувиар давуулан биелүүлсэн нь нөлөөлсөн байна.

Мөн аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого батлагдсан төлөвлөгөөгөөр 237592,5 мянган төгрөг, гүйцэтгэлээр 249460,3 мянган төгрөг буюу биелэлт 105,0 хувьтай, улсын төсөвт төвлөрүүлэх орлого төлөвлөгөөгөөр 25520,0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 97161,7 мянган төгрөг биелэлт 380,7 хувиар тус тус биелэсэн байна.

Төрийн сангийн төлөөлөгчийн гаргаж ирүүлсэн 2013 оны орлого, санхүүжилтийн нэгдсэн тайлангаар /нүүр тайлан/ Сумын орон нутгийн орлогын данс оны эхэнд 1216,1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Тайлант онд орон нутгийн төсөвт төвлөрөх орлогоор 60169,8 мянган төгрөг төвлөрсөн ба НҮҮ-ний санхүүгийн дэмжлэгээр 25431,9 мянган төгрөг, нийт 318601,7 мянган төгрөг төвлөрч, санхүүгийн дэмжлэгээс ЗДТГазарт 185866,9 мянган төгрөг, ИТХУралд 36205,4 мянган төгрөг, Багт 36359,6 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс

ЗДТГазарт 50527,4 мянган төгрөг , ИТХуралд 804,5 мянган төгрөг нийт 309763,8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Тусгай зориулалттай шилжүүлгээр ЕБСургуульд 644389,5 мянган төгрөг, Цэцэрлэгт 260719,4 мянган төгрөг, Эмнэлэгт 220881,6 мянган төгрөг, Соёлын төвд 51417,9 мянган төгрөг нийт 1177408,4 мянган төгрөгийн эх үүсвэрийг нэгтгэсэн байна. Дээрх байгууллагуудын жилийн эцсийн зарцуулаагүй төсвийн үлдэгдэл 7147,4 мянган төгрөгийг аймгийн төсөвт татсан, мөн цэцэрлэгийн хоолны хэмнэлт 2475,0 мянган төгрөгийг Мөнгөнморьт сумын цэцэрлэгт татан төвлөрүүлсэн, НЕҮйлчилгээний байгууллагуудын оны эхний харилцах дансны үлдэгдэл 8372,4 мянган төгрөгийг болон оны эцсийн зарцуулаагүй үлдэгдэл 9894,3 мянган төгрөгийг тус тус татан төвлөрүүлсэн байна

Халамжийн сангийн санхүүжилт 226649,9 мянган төгрөг төгрөгийг халамж үйлчилгээний санд төвлөрүүлснээс халамжийн тэтгэвэрт 142336,8 мянган төгрөг, жирэмсэн амаржсан эхийн тэтгэмжинд 46532,7 мянган төгрөг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт 11725,0 мянган төгрөг, нөхцөлт мөнгөн тусламж 9369,5 мянган төгрөг, амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 4255,0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 1976,8 мянган төгрөг , хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 10320,0 мянган төгрөг, банкны шимтгэл 134,1 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн дансны санхүүжилтээр ЗДТГазарт 39706,1 мянган төгрөг, Баг 284,8 мянган төгрөг, Сургууль 2253,8 мянган төгрөг, Цэцэрлэг 2000.0 мянган төгрөг, ЭМТөв 5493,3 мянган төгрөг нийт 49140,4 мянган төгрөгийн орлого, 48655,6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст 484,8 мянган төгрөгийн үлдэгдэлийг мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд нэгтгэсэн. Төсөвт байгууллагын өөрийн орлогоор Тамгын газарт 283,1 мянган төгрөг, Соёлын төв 780,5 мянган төгрөг, ЭМТөв 487,4 мянган төгрөг, Сургууль 440,6 мянган төгрөг, нийт 1991,6 мянган төгрөг нэгтгэгдсэн байна.

Мөнгөн хөрөнгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар оны эхэнд ЗДТГазар 8368.8 мянган төгрөг, ИТХурал 3.6 мянган төгрөг, Баг 1303.5 мянган төгрөг нийт 9675,9 мянган төгрөг, Тусгай зориулалтийн сангууд 8611.8 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 1216,1 мянган төгрөг, эм эргэлтийн сан 3932,8 мянган төгрөг, нийт 23436,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

Жилийн эцсийн байдлаар Тусгай зориулалтийн сангууд 34267,3 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 9080,6 мянган төгрөг, эм эргэлтийн сан 1658,5 мянган төгрөг, Нэмэлт төсвийн санхүүжилтийн дансны үлдэгдэл 484,8 мянган төгрөг нийт 45491,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Энэ Төрийн сангийн төлөөлөгчийн ирүүлсэн үлдэгдлийн баталгаагаатай болон ХААН банкнаас ирүүлсэн эм эргэлтийн сангийн үлдэгдлийн баталгаагаатай тохирч байна.

Авлага, өглөгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар Оны эхэнд 165719,9 мянган төгрөгийн авлага, оны эцэст 282763,8 мянган төгрөгийн авлагатай нэгтгэгдсэн ба оны эхнээс авлага 117043,9 мянган төгрөгөөр өссөн ба жилийн эцсийн нийт авлагын 280301,2 мянган төгрөгийн буюу 99,1 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Өглөг оны эхэнд 3357,9 мянган төгрөг, оны эцэст 16717,7 мянган төгрөгийн өглөгтэй нэгтгэгдсэн байна. Оны эхний үлдэгдэлээс 13359,8 мянган төгрөг өссөн нь Орон нутгийн хөгжил сангийн өглөг 16300,0 мянган төгрөг байгаа нь нийт өглөгийн 97,5 хувийг эзэлж байна

Бараа материал

Сумын нэгдсэн тайлангаар Бараа материалын данс нь оны эхэнд 118061,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 322339,2 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 289384,9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, жилийн эцэст 151016,0 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Оны эхний үлдэгдэлээс 32954,3 мянган төгрөгөөр бараа материал өссөн байна. Энэ нь мал амьтад 9265,0 мянган төгрөг, аж ахуйн материал 11778,7 мянган төгрөг, бусад хангамжийн материалын данс 10995,3 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлж байна.

Үндсэн хөрөнгө

Сумын нэгдсэн тайлангаар Үндсэн хөрөнгийн данс нь оны эхэнд 6414497,1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 200242,4 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 11154,4 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, жилийн эцэст 6603585,1 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Тайлант онд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдэл 188496,2 мянган төгрөг үлдэх өртөг 3846720,4 мянган төгрөг байна.

Тусгай зориулалтын сангууд

Сумын хэмжээнд 7 сан үйл ажиллагаа явуулж байгаа ба эм эргэлтийн сангаас бусад сан Төрийн сангийн харилцах дансаар гүйлгээ хийгдэж хянагддаг байна. Сангуудыг тодруулахад:

Байгаль хамгаалах сангийн талаар:

Байгаль хамгаалах сан оны эхний үлдэгдэл 185,5 мянган төгрөг, аймгаас санхүүгийн дэмжлэг 12000,0 мянган төгрөг, нөхөн төлбөр 1268,6 мянган төгрөг, торгууль 56,0 мянган төгрөг, худгийн ашиглалтын төлбөр 40,0 мянган төгрөг нийт 13364,6 мянган төгрөгийн орлого бүрдэж Мэргэжлийн хяналтын газрын тавигдсан актын төлбөр 1070,3 мянган төгрөг, Хогний сав авахад 800,0 мянган төгрөг, Байгаль хамгаалагч, БОУБайцаагч нарт 3 ажилтанд 3 хос дүрэмт хувцас нэг бүрийн үнэ 755,0 мянган төгрөг нийт 2265,0 мянган төгрөг, төвийн 4 худгийг хашаажуулахад 4000,0 мянган төгрөг, шатахуунд 1931,7 мянган төгрөг, бичиг хэрэг 23,0 мянган төгрөг, ХХМБагт цалин шимтгэл 350,9 мянган төгрөг нийт 10440,9 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 3109,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн талаар:

Орон нутгийн хөгжлийн санд тайлант онд аймгаас 104206,3 мянган төгрөгийн санхүүжилт, баяр наадмын хандив 9599,4 мянган төгрөг, ИТХ-ын 05/01 тогтоолоор 690,3 мянган төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн орлогоос санхүүжүүлсэн, нийт 114496,0 мянган төгрөг төвлөрч 99033,2 мянган төгрөгийн зарцуулж оны эцэст 15462,8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сумын ИТХ-ын 2013.04.03-ны өдрийн хуралдааны Орон нутгийн хөгжлийн сангийн эрэмбэлсэн жагсаалт батлах тухай 01 тоот тогтоолыг үндэслэн худалдан ажиллагаатай холбоотой ажил үйлчилгээг явуулсан байна.

- ✓ Сумын наадмын зардал 5000,0 мянган төгрөг батлагдсанаас сумын наадамд 6000,0 мянган төгрөг, аймгийн 90-н жилийн ойн наадмын 3148,0 мянган төгрөг нийт 9148,0 мянган төгрөг зарцуулж батлагдсанаас 4148,0 мянган төгрөг илүү зарцуулсан байна. Энэ нь баяр наадмын хандивын орлогоор 9599,4 мянган төгрөгийн эх үүсвэрээс зарцуулсан байна. Мөн хандивын орлогоор орон нутгийн телевизийн тоног төхөөрөмж авахад 2780,0 мянган төгрөг, тохижилтын зардалд 1594,7 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- ✓ Хог хаягдлыг цэвэрлэх зөөвөрлөх ажил 14600,0 мянган төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 15012,4 мянган төгрөгийг зарцуулж 412,4 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна. Энэ нь цалин шимтгэлд 9399,8 мянган төгрөг, шатахуунд 4564,5 мянган төгрөг, сэлбэгт 945,6 мянган төгрөг, хогны машины татвар даатгалд 102,4 мянган төгрөг зарцуулсан байна. Төсвийн тухай хуулиар Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогоор 2400,0 мянган төгрөг орсон боловч ХХМБаг 2-3 ажиллаж 15012,4 мянган төгрөгийн зардал гаргаж ажилласан ч хог хаягдлын хураамжийг бүрэн төвлөрүүлж ажиллаагүй байна. Сумын ИТХТ-ийн 67 тоот тогтоолоор тогтоосон хураамжийн тарифаар тооцвол тус суманд 1131 өрх сард 1000 төгрөгөөр, төв суурин газрын мал бүхий өрх 5000 мянган төгрөг, 30 үйлчилгээний газрууд 8000 төгрөг, амралт сувилал аялал жуулчлалын газар 15000 төгрөг, барилгын гаралтай хог хаягдал 10000 төгрөг, 6 Төсөвт байгууллага 43 ААНэгжийг 10000 төгрөгөөр тооцож нийт орлогын 80 хувиар тооцвол 17865,6 мянган төгрөгийн орлого орох боломжтой ба энэхүү орлогоор хог хаягдал тээвэрлэх зөөх зардлыг уялдуулан төлөвлөж баталж байх нь зүйтэй байна.
- ✓ Төвийн гудамжны гэрэлтүүлэг засвар 5400,0 мянган төгрөг , 3,4-р хороонд гэрэлтүүлэг шинээр тавих, засварын шат 35000,0 мянган төгрөг, Байгаль сууринд трансформатор шинээр авах 5000,0 мянган төгрөг нийт 45400,0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 32107,8 мянган төгрөг зарцуулсан байна.
- ✓ Сумын төвийн халаалт трас засан ажлын зураг төсөл 50000,0 мянган төгрөг батлагдсанаас 18980,0 мянган төгрөг зарцуулсан байна.
- ✓ Хороод руу явсан зам, төв гудамжны явган зам үерийн далан усны сувгийг засварлахад 9770,0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 8118,5 мянган төгрөг зарцуулсан байна.
- ✓ Худгуудад цэвэршүүлэх төхөөрөмж тавих 16265,5 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 950,0 мянган төгрөгөөр ус цэвэршүүлэгч төхөөрөмж авсан байна.
- ✓ Мал үржлийн үйлчилгээнд хээлтүүлэгч авахад 9265,0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр тус сумын “Чандмань Үржил” мал эмнэлэг гүйцэтгэхээр гэрээ байгуулан Увс аймаг дахь “Цөм сүргийн аж ахуй”-тай гэрээгээр “Баяд” үүлдрийн 36 хуц авсан байна.

Мал хамгаалах сангийн талаар:

Мал хамгаалах сан оны эхэнд 883,3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлант онд 2495,5 мянган төгрөгийн өвсний үнэ орж өвс татах шатахууны үнэ 982,5 мянган төгрөг, хуц малласан ажлын хөлс 165,6 мянган төгрөг, малчдын зөвлөгөөн 300,5 мянган төгрөг, үзэсгэлэн худалдаанд 498,4 мянган төгрөг, бусад зардалд 246,2 мянган төгрөг нийт

2193,2 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 1185,6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сүм хөгжүүлэх сангийн талаар:

Тайлант оны эхний үлдэгдэл 7071,1 мянган төгрөг тайлант онд ХЭДСангаас санхүүжилт 120000.0 мянган төгрөг, зээлийн эргэн төлөлт болон хүүгийн орлого 22940,1 мянган төгрөг, өвсний үнэ 2096,5 мянган төгрөг, худгийн төлбөр 950,4 мянган төгрөг, эргэн төлөлт 1200,0 мянган төгрөг, үрийн үнэ 380,0 мянган төгрөг нийт орлого 147566,9 мянган төгрөг байна. Тайлант онд 138500,0 мянган төгрөгийн зээл олгож өвсний үнэ 2075,5 мянган төгрөгийг Мал хамгаалах санд төвлөрүүлсэн, бусад зардалд 774,8 мянган төгрөг нийт 141350,3 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 13287,8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна

Бусад зардал зарцуулсан 774,8 мянган төгрөгийн зардлыг задлавал тариаланчдын зөвлөгөөнд 146,1 мянган төгрөг, шатахууны үнэ 199,2 мянган төгрөг, санхүүгийн программд 110,0 мянган төгрөг, зургийн аппарат бичиг хэргийн зардалд 319,5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Энэ нь сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт тавих үйл ажиллагаанд зарцуулах төсвийг 628,7 мянган төгрөгөөр баталсан төсөвт багтааж зарцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангийн талаар:

Тайлант оны эхний үлдэгдэл 21,9 мянган төгрөг аймгийн ИТХурлаас 2012 оны ажлаараа аймгийн хэмжээнд 1-р байранд орсонтой холбогдуулан 160,0 мянган төгрөгөөр шагнасан шагналын орлого орж зөвлөлийн гишүүдийн дунд гар бөмбөг болон ширээний теннисний тэмцээний шагналд 160,0 мянган төгрөг зарцуулж 21,9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна

Эмийн эргэлтийн сангийн талаар:

Эмийн эргэлтийн сан 3256,1 мянган төгрөгийн зарлага нь магадлан итгэмжлэх авахтай холбоотой зардалыг гаргасан байна. Үр дүнгийн тайлангаар 14300,0 мянган төгрөгийн борлуулалтын орлоготой, 13193,8 мянган төгрөгийн зардал гаргаж 1106,2 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны ашигтай үндсэн бус үйл ажиллагааны зардал 3256,1 мянган төгрөг нийт үйл ажиллагаа нь 2149,8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2013 оны эцэст мөнгөн хөрөнгө 1658,5 мянган төгрөг, бараа материал 6076,4 мянган төгрөг, Үндсэн хөрөнгө 4587,6 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй өр, авлагагүй байна. Нягтлан бодогч З.Энэбишдорж нь эргэлтийн эмийн сангийн харилцах дансны гүйлгээний 2-р гарын үсгийг зурдаггүй эмийн санчаар хийлгэсэн нь санхүүгийн тайланг мэргэжлийн нягтлан бодогч захиран зарцуулах эрхийг эдлэж хариуцлага хүлээх ба эмийн санчийн хувьд эд хариуцагчийн эрх үүргийн гүйцэтгэх үүргийг зөрчин нярав нягтлан бодогч гэсэн 2 албан тушаалд нэг хүн ажиллаж санхүүгийн хяналтыг хэрэгжүүлэх боломжгүй болгосон байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан хэсгүүдийн дотоод хяналтын систем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс

болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох тухай ИТХТ-ийн тогтоолоор тогтоосон тарифаар хураамжийн орлогыг төлөвлөж байх

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

1. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илрүүлсэн алдаануудыг төсөвт байгууллагуудад залруулсан ба нэгтгэлд залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

2. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

3. Аймгийн Аудитын газраас танай байгууллагын 2013 оны 12 дугаар сарын 31 –нээр тасалбар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014.03.25